

**БӨӨ МӨРГӨЛИЙН ЗАН ҮЙЛТЭЙ ХОЛБОГДСОН
МОНГОЛЧУУДЫН АМЬ АХУЙН УХАМСАР
(Одоо үеийн монгол түүхэн туужсийн жишээн дээр)**

Хасгуя

Бөө мөргөл бол монголчуудын эрт язгуураас шүтсээр ирсэн баларлаг шашин мөн. Бөө мөргөлийн шашны зан үйл хэмээгч Вальтер Хайсигийн хэлсэн мэт олон талын агуулгыг хамаарч байгаа боловч одоо хүртэл уламжлагдаж ирсэн нь тахилгын зан үйл ба өвчин заслагын зан үйл болно. Үүнд тахилгын зан үйлд нь тэнгэр тахих, онгод тахих, уул тахих, овоо тахих, дээдсээ тахих зэрэг агуулгыг багтааж, өвчин засах зан үйлд нь андай өвчнийг засах ба яс засах зэрэг агуулга багтана. Тус өгүүлэлд одоо үеийн монгол түүхэн туужист хүүрнэгдсэн бөө мөргөлийн шашны зан үйлтэй холбогдсон уул хайрхан, овоо шаншийг тахих зан үйл ба яс засах, хүүхэд хөнгөжүүлэх зан үйлээс монголчуудын амь ахуйн ухамсар болон амь насны ухамсрыг хайн шинжилнэ.

Нэг. Бөө мөргөлийн тахилгын зан үйл хийгээд амь ахуйн ухамсар

“Монгол хүн хэдэн мянган жилийн турш отор нүүдлийн мал малласаар амьдарч ирсэн хэрэг бөгөөд тэд жил турш халуун шатам нар, хахир өвлийн тасхийм хүйтэнд өвсний сайхан, усны тунгалгийг эрэн” (Гото Томио, 1990:1) отор нүүдэл хийхдээ ухаа сэргэлэн ой билгээрээ байгальтай олон талаар зохицох мэргэжлийг эзэмшиж, эх байгальдаа эгнэгшиж, эх байгалийнхаа буян хишигт шүтэн байж, хатуу бэрх орчин ахуй ба хүнд сүрхий ган зудаас таван хошуу мал сүргээ хамгаалж, өнөр өсгөх нүүдэл малжлын соёлыг үүдэв. “Монголчуудын нүүдэл малжлын соёл бол амь ахуйг хамгаалахад суурилсан соёл болохоор, монголчуудын сэтгэхүй хийгээд эчнээ ухвар нь эх байгалийн аливаа бүхэнтэй уусалтан нэвтрэлцдэг ажээ” (Хадач Ган, 2004). Ямарваа нийгэм орчинтой ч бүрмөсөн зохицож чаддаг бөө мөргөлийн шашин нь өөрийн шүтэн тахидаг эзэд онгод, эцэг тэнгэр, этүгэн эх, уулын сахиус, усны эзэд, дээдсийн сүнс зэргээ байгалилаг нүүдэл малжлын аж ахуйтай уусгаж, тусгайлан мал сүргийг хамгаалагч “заяач”, “буумал” зэргийн сахиусыг үүдэж, өөрийн шашиндаа амь ахуйг хамгаалах нүүдэл малжлын соёлын агуулгыг нэмэрлэв. Тэгээд тэнгэрийн тахилга, овооны тахилга, уул усны тахилга, дээдсийн тахилга, шанш модны тахилга зэрэгт цөм тахиж байгаа эзэд сахиусаасаа ан агналын олз омог, адуу малын үржил төлжил, аж амьдралын өөд эсрэгийг айлтган гуйх буюу гай барцадыг арилгаж, хор хөнөөлийг зайлуулахыг даатгаж, монголчуудын эх байгальдаа эгнэгшиж, эх байгалиа шүтэн тахиж, эх байгальтайгаа зохицолдож, эх байгалиа түшиж хамгаалах соёл ухамсартай ус цас шиг уусалдаж чаджээ. Яг иймээс “бөө мөргөлийн шашин нь хүсэл тачаалаа тэвчих, оюунлаг хайрыг хөөцөлдөх, байгалийн хүчнээс бишүүрхэх зэрэг элбэг баялаг амь ахуйн ухамсартай

байдаг. Тэр нь хүмүүсийн амьдралын хэлбэр ба байгалийн орчин тойрныг уян хатнаар зохицуулж, хүн ба байгалийг хамтаар хөгжүүлдэг” (汪淑东, 2008) хэмээн үнэлэгддэг байна.

“Байгалийн асуудал бол эцсийн эцэстээ соёлын асуудал болох юм. Байгалиа зөв таниж зүйтэй харьцаж, хайрлаж хамгаалж явна гэдэг нь эвдэлсний дараах сэргээх ажлыг хэлэх биш, харин нэг хүн, нэг үндэстний балчир багаасаа байгаль орчинтойгоо эрх тэгшээр зэрэгцэн оршиж явах үзэл ухамсар, соёл боловсрол жич үүний үндэстэй үйл ажиллагааг хэлнэ” (Зэвсэг, 2006:2). Гэвч нүднийхээ өмнөх ашгийг хардаг одоогийн хүмүүс үүнийг даанч орой ухаарч, байгалийн залхаал - байгалийн тачирлал, элсэн борооны хөнөөл зэргийг хүлээх л хэрэгтэй болсон. Нийгмийн бодисын соёлыг ихээр ахиулсан одоохчлолт нь өнөөдөр болоход “хүн төрөлхтнийг давж дийлшгүй гурван том түгшүүр - энергийн түгшүүр, амь ахуйн түгшүүр, оюун санааны түгшүүрт учруулжээ” (汪淑东, 2008). Иймээс “байгаль орчны асуудал, хүн хийгээд байгалийн эе зохицонгуй харьцааны асуудал бол 21 дүгээр зууны хүн төрөлхтний хамгаас илүү халамжилж, тэдний оршин тогтнол болон шинжлэх ухаанч бүх талын хөгжилтөд бачим, ноцтой тулгарч байгаа хүнд чухал асуудал юм. Тийнхүү хүн төрөлхтөн байгаль орчныг нандигнан хамгаалж, хүн хийгээд байгалийн эв зохицонгуй хамтран орших явдал бол шинэ зууны уран зохиолын хүнд чухал сэдэвлэхүүн болно гэдэгт хүмүүс нэгэнтээ түгээмэл танилт зөвшөөрөлтэй болж байна” (Рэнцэндорж, 2007:196). Нийгэм даяар хүндэтгэн анхаарч байгаа энэхүү хүнд чухал сэдэвлэхүүнийг монгол түүхэн туужист тусгахдаа бөө мөргөлийн шашны тахилгын зан үйл - овооны тахилга, шанш модны тахилга зэргээр дамжуулж, монголчуудын байгаль ахуйг бишрэн шүтэж, хайрлан хямгадаж, ээсэн зохицолдох уур соёлыг гайхуулан хүүрнэжээ.

“Тэнгэрийн увдис” романд маца бөөгийн арван настайдаа эцгээ дагаж овгийн алтан овоод мөргөхөөр ирээд “алтан яст хиадынхны алаг сүлд маань ашдын өлмийтэй үүрдийн үүрдээр зогсож, мөнх тэнгэрээ өнөдийн барлаар он онд ажиглаж бараалж байх учиртой” алтан овоо дээр бөөгийн шүтээн “тэнгэр” хэмээх үгийг аавынхаа амаас анх удаа сонсож, бөөгийн шүтээн шувууг анх үзсэн хэмээн алтан овоо, тэнгэр, шувуу, бөө зэргийг холбогдуулан зохиолоо эхлүүлжээ. Улмаар “овоо минь умар талаараа хөх мөнх тэнгэрээр түшлэг хийж, өмнөө үд дундын нараар харц болгож өлмий бат зогсоно. Тойронд нь үнэнхүү түмэн хүнд хурж, буман дайчдыг байлдаан зарлах бузгай уудам тал бараа хараа алдрам цалайна. Тэнгэр өөд тэрийн боссон хөхөлт модныхн нь алтан орой наранд гялалзаж, олон өнгийн хадаг няндарууд аясын салхинаа амьд юм шиг намилзахуй” гэх мэтээр монголчуудын нар хур тэгш, нэвтэг савдагтай газрыг сонгож овоо босгодог уламжлалт заншлыг нарийлаг бодитой тоочив. Бас арван гэрийн арван нэр ахай тайж нарын овоогийн тахилга дээр бөө нарын овоо тахилгыг эрхэлж, онгод шүтээнээ залсан, оршиж хүртсэн, тахилгын дээжээ өргөсөн, өчил өчиж сацал сацаж, адуу малынхаа өнөр өсөлт, аж амьдралынхаа өөд эсрэг байхыг гуйн даатгасан зан үйлийг нүдэнд үзэгдэм зураглажээ. Бас жишээлбэл: “Зоригт баатар Тогтох”-д, “Тогтох бол энэ хайрханд сүсэгтэй бөгөөд хайртай. Түүний гар нь ганзагад, хөл нь дөрөөнд хүрэх болсноос эцэг нь түүнийг дагуулж энэхүү овоон тахилгаанд ирдэг байсан юм. Ингэхдээ Тогтох удаа бүрийн дайн байлдаанд цөм энэ уул хайрхан ба овоо сүлддээ сүсэглэн даатгадаг байна. Энэ удаа журмын цэрэг нь нэг морь шархдаж, ганц хүн эндсэнгүйгээр үл барам, дайсныг илбэтэй шиг ялсан нь эцэг тэнгэр ивээж, овоон сүлд аварлаа гэж итгэдэг. Гэсэн ч тэр харин лам бурхан, гүрэм ном, сор догчироор дайсныг ялна гэдгийг ерөөс итгэдэггүй юм. Харин тухайн үед монголын удамшилт заншлаараа гурван бөөгөөр хэнгэрэг тогшиж, урилга дуудлага гиншиж тахиж байсан тул Тогтохын тархинд гүн суугдал өгжээ” (Боржигон Эрхэмбат, 1993:198).

“Гад мэйрэн”-д, сүмийн зүүн хавьд тосгоны төв чигийг эзлэн оргосон нэг суурь өндөр бүдүүн хундар мод ганцаар ойгоос тусгаарлан саглайж байдаг нь тусгай шанш тахидаг мод мөн. Өнгөрсөнд тэнгэр гандмагц айл аймгийн олноороо шанш тахиж тэнгэр лусаас бороо гуйдаг ажээ. Тэгэхэд мөнгөн цагаан сахалтай нэгэн өвгөн цан барин цохиод: “дүн

ца ца \ дүн ца ца \ энэ өдөр буухгүй бол \ маргааш буутугай! \ Эцэг тэнгэрээс бороо гуйж байна...” (Энэрэлт, 1989:75) гэхчлэн тарни унших шиг урсам сайхан ярьж аялуулдагсан. Энд монголчуудын шанш модыг тахиж бороо гуйж байсныг тэмдэглэж буй. Үнэндээ шанш модыг тахих бол эртний монголчуудын уламжлалт бөө мөргөлийн шашны тахилгын зан үйлийн нэг мөн. Энэ тухай Сөөө “балар эртний монгол овог ястан, ямар нэгэн баяр хурим, жишээлбэл ав шувуу, аян дайны амжилт, эсхүл аюул гамшгийг тонилгохын улмаас тогтсон нэгэн газар хурж олуулаа (саглагар мод орчиж) дуулан бүжиглэж эцэг тэнгэр, этүгэн эх, уул усны эзэд сахиулсан, өвөг дээдсээ баясгаж өршөөл соёрхлыг хүсэх буюу баяр талархлаа илтгэж байжээ” (Сөөө, 1998:524) гэжээ. Шанш модын тахилгатай адилаар монголчуудын уул хайрхан (овоо)-ий тахилга нь ч эртнээс уламжлалтай байдаг. Тухайлвал, “Монголын нууц товчоон”-ий 103 дугаар зүйлд Тэмүжин Бурхан халдун ууланд нуугдаж, мэргидийн дайралтаас дутааж гарсны сүүлээр “(...халдун бурхана \ харцын төдий амнаа \ халхлагдав яа би.\ Маш айуулдав би. \ Бурхан халдуныг \ манагаар бүр \ мялаасугай! \ Өдөр бүр \ өчсүгэй! \ Ургийн ураг минь \ ухтугай!) хэмээн нарны эсрэг бүсээ хүзүүн дээрээ эрхэлж, малгайгаа гар дороо сэхжээлж, гараа өвчүүн дороо мунхалдаж, нар зүг сөгдөж, сацал өчүүл өгөв” (Монголын нууц товчоо, 1981:247-251) хэмээн нарийлаг тэмдэглэж байдаг.

Монголчуудын иймэрхүү уламжлалт шүтлэгийн зан үйл нь одоо үеийн түүхэн туужист тусгагдахдаа амь ахуйн сэдэвлэхүүн болж хувирчээ. Даруй “Тэнгэрийн увдис”, “Зоригт баатар Тогтох”, “Гад мэйрэн”, “Наран саран мод”, “Бэйлийн гурван овоо”, “Урьхан хавар” зэрэг бүтээлд бөө мөргөлийн шашны тахилгын зан үйл нь монголчуудын эх байгальдаа хайртай, эх байгалийн үр болсон хүн амьтан, араатан жигүүртнийг хүртэл хайрлаж хамгаалж өөрийн оройн шүтээнээ болгодог ухамсартай уусалцан, уул хайрхан, овоо шаншийг онгод шүтээнээ болгож, байгаль дэлхийгээ хайрлан түшиж явдаг уламжлалт амь ахуйн ухамсартай холбогдон хүүрнэгдэв.

Хоёр. Өвчин заслагын зан үйл хийгээд амь насны ухамсар

Монголчуудын өвөг дээдэс олон мянган жилийн тэртээгээс үүсэж мэндэлсэн өндөрлөгийнхөө уудам их хээр талын өрцөд “усны тунгалаг, өвсний соргог”-г хөөж нүүдэллэн малжиж, өнөр баян байгалийн хишиг буянд шүтэж аж төрөн амьдрахдаа баатарлаг, нээлтлэг, зохицонгуй монгол соёлыг үүдсэн бөгөөд уудамч, өгөөмөр, өрөвч монгол сэтгэлгээг бүрэлдүүлжээ. Энэхүү монгол соёл сэтгэлгээнд шалтгаалагдаж монгол хүнд хүн байгалийн шүтэлцээг чухалчилсан өвөрмөц амь насны гүн ухаантай байдаг. “Монголчуудын амь насны гүн ухаан бол хүн байгалийн нэгдэлд оршихуйн чиглэлт сэтгэлгэн болно. Тэдэнд авч хэлбэл байгаль бол амь нас, тэр нь зөвхөн бодислаг оршихуй төдий бус, харин оюуны ба бодисын хос ишт оршихуй юм” (Цолмон, 2007:311). Иймээс “Монголчууд амь нас бүхэн хорвоод амьдран орших тэгш эрхтэй гэж үздэг. Амьдрахын төлөө тэмцэж эх дэлхий дээр газар дэлхий дээр газар эзлэн явахын хувьд эрх тэгш байхыг санадаг мөртлөө, амь зуухын хувьд ч түмэн амьтны амь насандаа хандах овор ч эрх тэгш гэж үзээд, хүн ба амьтан нь эх байгалийн үр хүүхэд болсны хувьд амьтнаас ялгаагүй гэж үздэг байв” (Цү И, 2013:210).

“Тэнгэрийн увдис” романд ахин дахин давтагдан хэлэгддэг “амь нас, амьтан хүн аль алиндаа адил! Аль алиндаа уйланхай, хайланхай өө...” хэмээдэг нь монголчуудын амь нас бол хүн амьтанд эрх тэгш адилхан хэмээх амь насыг хүндэтгэх ухамсрыг илтгэсэн байхад, “энэ өндөр тэнгэр, тэр уудам дэлхий дээр наргүй бол хургүй, хургүй бол усгүй, усгүй бол амьгүй, амьгүй бол өөрсдөө мануус оршин тогтнож чадахгүй л дээ!” гэдэгт амь ахуйн холбоо, амь насны оршлын тухай танилтыг тусгажээ. Үүгээр үл баран, “Тэнгэрийн увдис” романд наран авай удганы өвчин заслын зан үйлийн хүүрнэлээр дамжуулж, амь насны оршил, амь насны эрх, амь насны өртгийн тухай тунхалт хийв.

Наран авай удган бол хорчны алдарт бөө амьхан хайчин ахай бөөгийн шавь гурван үеэрээ бөө бариач явсан нэрт удган мөн. Арван зургаан наснаасаа бөөгийн суудалд сууж тоогүй олон хүнийг засаж эдгэж явсан түүхтэй. Наран авай удганы өвчтөнийг зассан байдлыг дөхөм жагсаавал: яс гэмтсэн адуучныг засаж ясан заслагаа эхлүүлсэн; цагаан даяанч дөрөвдүгээр хутагт ламыг засаж эдгээгээд, өвгөн манрамбатнаас төвдийн тэжээхүй ухаан, хятадын дотор эмнэлгийн ухаан жич ханалга төөнөлөг зэргийн эмчилгээний эрдмийг сурсан; бэрх хучлага болсон чоныг хөнгөжүүлж, эрдэнийн бурцаг олсон; гурав тасарсан могойг залгаж эдгээгээд эрдэнэ “могой эрэн чулуу” олсон; цариг эрт чөмөг ясаа тас цохигдон дамбарсан бүсгүйг эдгэж мөнгөн бугуйвчаа мулталж эм залж уулгахаар балагласан; мөнгө зааж “буян” үйлддэг “зоосон дотор”-той гүртэмбийн заарсан эрүүг засаж, төлөөс харамжид авсан тоймог үнээ доголыг нь ятгаж буцаалгасан; үнэн ба худал өвчтөнийг ялган таниж засан эдгэрүүлээд Нороврэнцэн Да Ваныг бишрүүлсэн ... гэх мэт аль олон хүн амьтны амийг аварч, ач тус хүргэв. Наран авай удганы хүү нарт бөө тэрэм ч дүрт зүтгэлтэйгээс бодлогот Цэн Ван Сэнхэрэнцэн, түмэнд хорсолтойгоос Япон солиг, дүрийн цариг балуу жич төвөгдөж гачигдсан олон хүнийг засаж эдгэрүүлсэн юм. Тэд өвчтөнийг засахдаа ерөөс ялган үздэггүй. Ноён ба ард, харц ба лам, баян ба ядуу, танил ба төрөл, өшөөтөн ба дайсан, хүн ба амьтан аль нь гэсэнгүй өвчинтэй л бол засаж, амьтай л бол авардаг бөгөөд Наран авай удганаар “амь нас, амьтан хүн аль алиндаа адил! Аль алиндаа уйланхай, хайланхай өө ...” гэж дахин дахин хэлүүлдэг байна. Бөө нарын иймэрхүү эмчилгээний зан үйлд нь монголчуудын амь насыг хайрлаж эрхэмлэдэг өрөвч зөөлөн сэтгэл ба амь насыг эрх тэгш хүндэтгэдэг соёл ухамсар шингэв.

“Ганган хар” романд Цорж Жонрай гүргэмийн авааль эхнэр Оюундарьтай ханилж түүний хайрыг удаан өмчирхөж, бас Оюундарийн энэ гэр дэх байр суурийг нь бататгаж, өөрийн хүү Бинээгээ энэ айлын хүргэн болгож, авдар дүүрэн эд хөрөнгийг нь өмчлүүлэхийн төлөө гүргэмийн бага эхнэр Сэцэндарийн хүүтэй болж Оюундарийн байрыг булаахаас эмээж, гэм хийж мориноос нь хаягдуулж хөлийг нь хугалж, орог унуулах гээд дийлсэнгүй болохоор хүүг нь адын сүнс хэмээн амьдаар нь булж орхисон байхад, Жамъян бөө харин Сэцэндарийн хугарсан хөлийг засаж эдгэрүүлж, бас бэрх хучлагыг нь засаж байгаад хүүг нь амар мэндээр хөгжүүлсэн байна. Романд Цорж Жонрай болон Жамъян бөө хоёулын нэг нь Сэцэндарийг хорлож, нэг нь Сэцэндарийг аварч байх зөрчил будлиант үйл явдлыг харьцуулан хүүрнэхээр дамжуулж, бурхны шашны “эх болсон зургаан амьтныг аюулаас гэтэлгэх”-ийн төлөө хэмээн номлодог боловч үнэндээ хувийн ашиг тусынхаа төлөө бусад хүний амь насыг үрэгдүүлж, хор хөнөөл хийдгийг шүүмжилж, бөө мөргөлийн шашны амь насыг хайрлаж хамгаалж хүнд тус хүргэдгийг магтжээ.

Үүнээс гадна, “сансрын хүрд”-д гарди бөөгийн Ли Сахулийн өвчнийг засан эдгэрүүлсэн, “Наран саран мод”-д тэрэм бөөгийн нэрс Бэйлийн хөлийг засаж эдгэрүүлсэн зэрэгт ч монголчуудын амь насыг эрхэмлэх, хүндэтгэх, хайрлах уламжлалт ухамсрыг илрүүлэв.

Монгол бөө мөргөлийн шашны сэдэвлэхүүнт романд дээрх мэтээр амь насны хайрын ухамсрыг илэн далангүй илрүүлж байхын зэрэгцээгээр амь насыг үрэгдүүлэх ухамсрыг ч хааяа илрүүлж байдаг. Энэ нь даруй бөө удган нарын үр шавьдаа өөрийн эрдэм чадвар “сударгүй ном”-оо сургаж, бөөгийн “суудал”-аа залгамжлуулахдаа өөрийн амь насаа үрэгдүүлж, онцгой нэгэн зүйлийн зураг өөрийн биений “араг ясны зураг”-аар хүн төрөлхтний бие дээрх хоёр зуу бөгөөд зургаан хэсэг ясыг үзүүлэн таниулж, ясан заслыг сургахыг хэлж буй. Ёгорон бөөгийн үр шавь Амьхан Хайчин Ахайг бөөгийн суудалд суулгаж, өөрөө сүмэн сүмэн сөрлөн модон замаар “тэнгэрийн суудал”-даа буцсан; Амьхан Хайчин Ахай бөөгийн үр шавь наран авай удганыг бөөгийн суудалд суулгаж, өөрөө сүмэн сүмэн сөрлөн модон замаар “тэнгэрийн суудал”-даа буцсан зэрэг нь даруй бөө нарын бусдын төлөө өөрийгөө үрэгдүүлэх онцгой нэг зүйлийн амь насны өртөгийн үзэлт болно.

Ерөнхийлбөл, эх байгаль бол нэг том органик бүтэн цогц мөн. Энэхүү органик цогцод хорвоогийн хүн амьтан, ургамал бодис цөм харилцан түшилцэн оршдог. Одоо үеийн монгол

түүхэн туужисийн бөө мөргөлийн шашны зан үйлийн хүүрнэл дахь уул хайрхан, ус мөрөн, овоо шаншдаа эзэд шүтээнтэй хэмээн халдаж болшгүй “онгон сэтэр” зүүлгэн тахидаг заншил, “энэ өндөр тэнгэр, тэр уудам дэлхий дээр наргүй бол хургүй, хургүй бол усгүй, усгүй бол амьгүй, амьгүй бол өөрсдөө мануус оршин тогтнож чадахгүй л дээ!” хэмээх амь ахуйн холбоо, амь насны оршлын тухай танилт, “амь нас, амьтан хүн аль алиндаа адил!” хэмээх амь нас бүхэн нь хорвоод амьдран орших тэгш эрхтэй хэмээх мэдрэмж нь монголчуудын амь ахуйн орчин тойрныг хамгаалахад идэвх үйлдэл үзүүлсээр иржээ.

Номзүй

Боржигон Эрхэмбат. *Зоригт баатар Тогтох.* Үндэстний Хэвлэлийн Хороо, 1993.

Гото Томио. *Монголын отор нүүдлийн нийгэм.* Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. Хөххот, 1990.

Зэвсэг. *Монгол соёл дахь байгаль, нийгмийн шүтэлцээт хөгжил.* Үндэстний хэвлэлийн хороо, Бээжин. 2006.

Монголын нууц товчоо. Баяр галиглав. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1981.

Рэнцэндорж Ж. *Шинэ эриний монгол уран зохиолын шүүмжлэл.* Үндэстний хэвлэлийн хороо, 2007.

Сөөө. *Утга уянгын тольт.* Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1998.

Хадач Ган. *Мандмуйн үзэгдэл: Соёл ба амь ахуйн комплекс.* Алтан түлхүүр. №2. 2004.

Цолмон Ц. *20 дугаар зууны сүүлчийн 20 жил дахь монгол туужсгийн одооч хэлбэр.* Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2007.

Цү И. *(Шинэ эрин)-ий монгол туужсгийн уламжлалт соёл ухамсрын хувьсал.* Өвөр Монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 2013.

Энэрэлт. *Гад мэйрэн.* Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1989.

汪淑东 “生态意识与当代文学”, 中国社会科学出版社, 2008年, 第200、第4页。